



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод Нийтийн Аж ахуй ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/З/СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Д.Нармандах Утас: 70584207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
Менежментийн захидал	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	13
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	16



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.03.13 № 490

танай _____-ны № _____-т

Г ДОРНОД НИЙТИЙН АЖ АХУЙ
ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.БАЯРСАЙХАН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон тодруулга тайланг материаллаг зүйлсийн хувьд стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520210



Үүрэг, хариуцлага

Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандартуудтай нийцүүлэн түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Г.Баярсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллах талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 65 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.



Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хэрэглэгчдийн стандартад нийцсэн цэвэр усаар хангах, түүнээс гарсан бохирыг татан зайлуулж, цэвэрлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон сууцны айл өрх, аж ахуй нэгж байгууллагад төвлөрсөн шугам сүлжээгээр дулаан, хэрэгцээний халуун хүйтэн ус дамжуулан түгээх.
- Засвар үйлчилгээг хариуцах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Винница” санхүүгийн программ хангамж ашигласан байна.

Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд 13 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны



жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,858,442.8 мянган төгрөгөөс тооцон 38,584.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 43,675.7 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд орлогын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,014.0 мянган төгрөгөөр буюу 0,4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо, хуримтлагдсан ашиг дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,040,777.6	2,371,339.6	33,056.2
Авлага	366,947.0	397,003.3	30,056.3
Бараа материал	78,431.7	163,167.3	84,735.6
Үндсэн хөрөнгө	13,452,130.9	13,708,111.3	255,980.4
Хуримтлагдсан элэгдэл	-2,413,628.3	-3,164,976.7	-751,348.4
Нийт хөрөнгө	13,524,658.9	13,474,644.9	50,014.0
Өр төлбөр	3,279,180.4	3,309,978.6	30,798.2
Хуримтлагдсан ашиг	-46,241.8	-214,588.1	-168,346.3
Засгийн газрын оролцоо /эздийн өмч/	7,097,112.5	7,184,646.5	87,534.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,194,607.8	3,194,607.8	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	13,524,658.9	13,474,644.9	50,014.0

Авлага дансны үлдэгдэл өссөн нь аж ахуй нэгж байгууллагууд төвлөрсөн шугам сүлжээгээр дулаан, хэрэгцээний халуун, хүйтэн усны төлбөрийг цаг хугацаандаа төлөөгүйгээс шалтгаалжээ. Авлага дансанд байгууллагаас авах 389,866.5 мянган төгрөгийн, хувь хүнээс авах 7,077.7 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар “Шинэ усан сан-5” төслийн хүрээнд Хэрлэн сумын 1,2-р багт байрлах ус түгээх 2 байрыг барихад шаардлагатай барилгын материалыг шилжүүлэн өгснөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь айл өрхөөс авах авлагаас шалтгаалжээ.



Хөрөнгө оруулалтаар 29,996.4 мянган төгрөгийн ус түгээх байр, хандиваар хүлээн авсан мянган төгрөгийн 16,500.0 мянган төгрөгийн автомашин, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй 24,672.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, өөрийн хөрөнгөөр 89,812.5 мянган төгрөгийн барилга байгууламж, 90,361.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 9,767.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авснаар нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 5,130.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгөнд тайланд онд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь урьдчилж орсон орлогоос шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр 2003 оноос үүссэн Азийн хөгжлийн банкнаас авсан 3,254,033.3 мянган төгрөгийн өр байгаа бөгөөд нийт өр төлбөрийн 98,3 хувийг эзэлж байна.

Бусад 55.945.3 мянган төгрөгийн өр нь аж ахуй нэгжээс урьдчилж төлсөн орлогоос шалтгаан үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,184,646.5 мянган төгрөг болж 87,534.0 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгад тайланд онд бичилт хийгдээгүй байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор тайлант онд 2,758,737.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 3,012,487.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109.2 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд 3,162,039.2 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулахаар, 402,922.2 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 3,176,238.8 мянган төгрөгийг зарцуулан, 168,346.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 13 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 3,257,606.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,255,282.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 2,324.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 3,255,282.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:



1. Санхүүгийн тайлангийн мал дансанд бүртгэлтэй нийт 557.7 мянган төгрөгийн 18 толгой малын үнэ зах зээлийн үнээс хэт доогуур үнэлгээтэй, худалдан авсан 9,6 сая төгрөгийн өртөгтэй “unicus” программ хангамж ашиглалтгүй, санхүүгийн бүртгэл хөтөлж байгаа “Винница” программ хангамжийг 2018 онд бүртгэлээс хассан байна. Энэ нь НББОУС 41, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ, оршин байх, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

2. Азийн хөгжлийн банкнаас авсан 3,254.0 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өглөгийн тооцоо нийлсэн акт байхгүй, анхны дүнгээс өөрчлөгдөөгүй, гэрээнд зээлийн хүүг жилд 2 удаа, үндсэн төлбөрийг 2010 оноос эхлэн төлөхөөр тусгасан ч өнөөдрийг хүртэл хүүг тооцон бүртгэлд тусгаагүй, зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт хийгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь хэсэгт “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

Аудитаар илэрсэн 2,324.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэж байна. Тухайн хөрөнгүүдийн элэгдлийн зардал өндөр байгаагаас санхүүгийн тайлан алдагдалтай илэрхийлэгдэж байна. СТОУС-д заасны дагуу тайлант оны элэгдлийн дүнгээр хөрөнгийн орлогыг хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх талаар өмнөх аудитуудаар зөвлөмж өгсөн ч хүлээн зөвшөөрсөн орлогын дүнд НӨАТ-тухай хуулийн дагуу татвар төлөх нөхцөл байдал үүсэж байгаагаас зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Иймд уг орлогыг НӨАТ-аас чөлөөлүүлэх талаар хууль, эрх зүйн зохицуулалт хийлгэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх талаар аймгийн ТЕЗ-ийн нэгтгэлд тусгуулахаар шийдвэрлэв.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ бүрэн байршуулсан байна.



2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 23.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 1 зөвлөмж өгсөн нь хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын дансны талаар

- 1.1. Илрүүлэлт: Удирдлагын тээвэр шатахууны зардлыг төлөвлөгөөнөөс 77.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.
- 1.2. Эрсдэл: Хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь хэсгийн “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг мөрдөн ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

2. Дотоод хяналтын талаар

- 2.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн нөөцийн бараа дансанд тусгагдсан 2,246.0 мянган төгрөгийн хөрөнгийн бүртгэл байхгүй, тооллогод хамруулаагүй байна.
- 2.2 Эрсдэл: Ашиглан үүсэх магадлалтай.
- 2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь хэсгийн “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтыг мөрдөн ажиллах.



2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2 486 156 315,97	2 931 510 235,80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2 040 777 605,52	2 371 339 654,90
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	10 674 926,58	9 409 676,95
31110	Төгрөг	5 997 236,58	4 583 279,95
31120	Гадаад валют	4 677 690,00	4 826 397,00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2 030 102 678,94	2 361 929 977,95
3121	Төгрөг	2 030 102 678,94	2 361 929 977,95
31213	Арилжааны банк дахь харилцах	2 030 102 678,94	2 361 929 977,95
33	АВЛАГА	366 947 021,29	397 003 313,60
33401	Дансны авлага /ТӨҮГ/	358 779 130,25	389 866 499,29
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	4 480 322,14	59 152,55
335	Бусад авлага	3 687 568,90	7 077 661,76
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3 687 568,90	7 077 661,76
35	БАРАА МАТЕРИАЛ	78 431 689,16	163 167 267,30
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		80 000 000,00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	11 321 887,41	12 892 843,58
354	Хангамжийн материал	64 408 257,25	67 469 899,66
35410	Бичиг хэргийн материал	1 917 340,30	1 155 514,92
35430	Сэлбэг хэрэгсэл	55 933 644,18	59 934 384,71
35440	Түлш, шатах тослох материал	225 454,59	48 181,85
35470	Бусад хангамжийн материал	6 331 818,18	6 331 818,18
35500	Бусад нөөц	2 246 845,42	2 246 845,42
35600	Мал амьтад	454 699,08	557 678,64
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11 038 502 548,64	10 543 134 631,00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11 038 502 548,64	10 543 134 631,00
392	Биет хөрөнгө	7 253 253 548,64	6 757 885 631,00
39201	Барилга, байгууламж, орон сууц	6 874 012 445,63	6 993 821 279,63
39202	Хуримтлагдсан элэгдэл	779 211 028,03	1 331 875 387,57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	995 522 186,80	1 012 022 186,80
39204	Хуримтлагдсан элэгдэл	790 822 817,90	847 740 591,34
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1 625 908 947,95	1 736 493 814,95
39206	Хуримтлагдсан элэгдэл	738 051 605,55	865 167 671,98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30 273 679,79	39 360 410,29
39208	Хуримтлагдсан элэгдэл	21 788 522,26	22 919 850,52
39214	Бусад үндсэн хөрөнгө	141 164 620,52	141 164 620,52
39215	Хуримтлагдсан элэгдэл	83 754 358,31	97 273 179,78
393	Биет бус хөрөнгө	3 785 249 000,00	3 785 249 000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	3 785 249 000,00	3 785 249 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13 524 658 864,61	13 474 644 866,80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3 279 180 418,40	3 309 978 654,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25 147 075,40	55 945 311,00
413	Өглөг	25 147 075,40	37 763 492,82
4136	Бусад өглөг	25 147 075,40	37 763 492,82
41361	Байгууллагад төлөх өглөг	25 089 722,59	12 831 968,01
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,00	270 908,27
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	57 347,81	24 660 616,54
414	Урьдчилж орсон орлого	-	18 181 818,18
41440	Бусад урьдчилж орсон орлого		18 181 818,18
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3 254 033 343,00	3 254 033 343,00
422	Урт хугацаат зээл	3 254 033 343,00	3 254 033 343,00
4222	Гадаад валют	3 254 033 343,00	3 254 033 343,00
42224	Төслийн зээл	3 254 033 343,00	3 254 033 343,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10 245 478 446,21	10 164 666 212,80
51	Засгийн газрын хувь оролцоо	10 245 478 446,21	10 164 666 212,80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7 097 112 462,16	7 184 646 508,16
51101	Өмч: - төрийн	467 926 157,11	467 926 157,11
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	6 122 462 205,05	6 716 720 351,05
512	Хуримтлагдсан үр дүн	(46 241 816,68)	(214 588 096,09)
51210	Өмнөх үеийн үр дүн	77 589 133,06	(46 241 816,68)
51220	Тайлант үеийн үр дүн	(123 830 949,74)	(168 346 279,41)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3 194 607 800,73	3 194 607 800,73
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13 524 658 864,61	13 474 644 866,80



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2 321 124 384,79	2 671 601 191,84
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2 321 124 384,79	2 671 601 191,84
110	Орлогын албан татвар	2 321 124 384,79	2 671 601 191,84
1100	Хувь хүний орлогын албан татвар	2 321 124 384,79	2 671 601 191,84
110002	Үйл ажиллагааны орлого	2 321 124 384,79	2 671 601 191,84
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2 376 258 809,91	2 948 845 844,97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 376 258 809,91	2 948 845 844,97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 376 258 809,91	2 948 845 844,97
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2 376 258 809,91	2 948 845 844,97
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	2 208 489 495,33	2 759 039 669,98
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	159 454 720,42	185 211 669,99
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	8 314 594,16	4 594 505,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(55 134 425,12)	(277 244 653,13)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	234 063 400,30	340 886 581,26
145003	Хөрөнгө оруулалтын олз	234 063 400,30	340 886 581,26
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	302 759 924,82	231 988 207,54
225008	Дотоод эх үүсвэрээс олгосон зээл	302 759 924,82	231 988 207,54
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(68 696 524,52)	108 898 373,72
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(123 830 949,64)	(168 346 279,41)



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3 858 442 808,53	4 367 546 670,28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3 858 442 808,53	4 367 546 670,28
120	Нийтлэг татварын бус орлого	3 858 442 808,53	4 367 546 670,28
120009	Бусад орлого	119 718 559,94	46 243 432,50
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	3 723 787 086,59	4 317 716 374,78
120015	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/	14 937 162,00	3 586 863,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3 560 068 657,37	3 775 873 546,90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3 560 068 657,37	3 775 873 546,90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3 560 068 657,37	3 775 873 546,90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	952 099 558,70	1 108 068 125,95
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	952 099 558,70	1 108 068 125,95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	260 961 571,94	329 513 351,75
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	260 961 571,94	329 513 351,75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1 128 503 891,92	1 191 408 631,73
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	1 128 503 891,92	1 191 408 631,73
2104	Хангамж, бараа материалын зардал	408 125 020,73	399 777 297,45
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	1 029 600,00	20 244 400,00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	407 095 420,73	379 532 897,45
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	810 378 614,08	747 106 140,02
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	297 414 407,46	300 743 288,73
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/		15 294 990,00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	512 964 206,62	431 067 861,29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	298 374 151,16	591 673 123,38
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	110 574 136,27	261 111 074,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	110 574 136,27	261 111 074,00
2200	Дотоод эх үүсвэрээр	110 574 136,27	261 111 074,00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	110 574 136,27	261 111 074,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(110 574 136,27)	(261 111 074,00)



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467 926 157,11	550 773 875,07	77 448 809,08	2 805 473 204,05	3 901 622 045,31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	467 926 157,11	550 773 875,07	77 448 809,08	2 805 473 204,05	3 901 622 045,31
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		2 643 833 925,66		3 823 713 101,00	6 467 547 026,66
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			140 323,98		140 323,98
C07	Тайлант үеийн үр дүн			-123 830 949,74		-123 830 949,74
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467 926 157,11	3 194 607 800,73	-46 241 816,68	6 629 186 305,05	10 245 478 446,21
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467 926 157,11	3 194 607 800,73	-46 241 816,68	6 629 186 305,05	10 245 478 446,21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	467 926 157,11	3 194 607 800,73	-46 241 816,68	6 629 186 305,05	10 245 478 446,21
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				87 534 046,00	87 534 046,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0,00
D08	Тайлант үеийн үр дүн			-168 346 279,41		-168 346 279,41
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467 926 157,11	3 194 607 800,73	-214 588 096,09	6 716 720 351,05	10 164 666 212,80